



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2019 оны 12 дугаар сарын 06
№46 /1099/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Оюу толгой ордын ашиглалтад
Монгол Улсын эрх ашгийг
хангуулах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Монгол Улсын Засгийн газрын
Хүндэт өргөмжлөл, гэрчилгээний
загвар, журам батлах тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол**

**Ашигт малтмалын тухай хуулийн
47 дугаар зүйлийн зарим хэсэг,
заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
эцэслэн шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

393.	Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 90	1762
394.	Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 91	1762
395.	Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай	Дугаар 92	1763
396.	Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох тухай	Дугаар 94	1764
397.	Санхүүгийн зохицуулах хорооны даргыг нөхөн томилох тухай	Дугаар 95	1765

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

398.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 204	1765
399.	Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 205	1766
400.	Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилох тухай	Дугаар 206	1766

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

401.	Журам батлах тухай	Дугаар 246	1766
402.	Горим батлах тухай	Дугаар 267	1770
403.	Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл, гэрчилгээний загвар, журам батлах тухай	Дугаар 271	1776

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

404.	Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 04	1780
------	---	-----------	------



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Содномдаржаагийн Даваасүрэнг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-г даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Ви Ви Ай) Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Оюу Толгой ХХК хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” 40 дүгээр тогтоол, 2009 оны “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах;

2/Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах;

3/Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд зааснаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;

4/Оюу толгой ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартын дагуу дахин хийж, үүнд үндэслэсэн техник, эдийн



засгийн үндэслэлийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах;

5/Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 тоот “Газрыг улсын хэрэгцээнд авах тухай” тогтоолыг өөрчилж, говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох;

6/Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах;

7/Оюу толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Т.Аюурсайхан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалттай холбогдуулан Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг нөхөн томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэмбэрэлдашийн Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргаар нөхөн томилсугай.

2. Энэ тогтоолыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 204

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 24 дүгээр зүйлийн 24.6, 24.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан шүүгч Цэвэгмидийн Зоригийг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 205

Улаанбаатар
хот

Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн "Журам батлах тухай" 213 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар
хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Доржгочоогийн Ариунтуяа, Баатарын Энхтунгалаг нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 246

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 33.12, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11.10-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 200 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Н.ЭНХБОЛД

Засгийн газрын 2019 оны 246 дугаар
тогтоолын хавсралт

**ИРГЭН, ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙГ
ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БОЛОН
ЦЭРГИЙН СУРГАЛТ, ЦЭРГИЙН ДАЙЧИЛГААТАЙ СУРГУУЛЬД
ОРОЛЦОХ ХУГАЦААНЫ ЦАЛИН ХӨЛСНИЙ ДУНДАЖ
ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтний орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалтад хамрагдах, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг хуваарилах, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад гүйцэтгэсэн үүрэг, оролцоог үнэлэх замаар сургалт зохион байгуулагч байгууллага цалин хөлсийг тухайн сургалтын төгсгөлд олгоно. Сургалтад гүйцэтгэсэн үүрэг, оролцоог сургалтын хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрхэн биелүүлсэн байдлаар нь үнэлнэ.

Хоёр. Орон нутгийн хамгаалалтын сургалтад хамрагдсан
иргэнд олгох цалин хөлс

2.1. Орон нутгийн хамгаалалтын цугларалт, хээрийн дадлагад хамрагдсан иргэний цалин хөлсийг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар олгоно.

2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хамгаалалтын цугларалт, хээрийн дадлагад хамрагдах иргэний тоо, тэдэнд олгох цалин хөлсний зардлыг тооцож аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн орон нутгийн төсөвт тусуулна.

2.3. Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль зохион байгуулах шийдвэрийн дагуу нэгдсэн сургуульд оролцсон иргэнд олгох цалин хөлсийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Гурав. Цэргийн сургалтад хамрагдсан цэргийн
бэлтгэл үүрэгтэнд олгох цалин хөлс

3.1. Цэргийн сургалтад хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтний цалин хөлсийг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны тогтоолыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги олгоно.

3.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб дараа жилийн цэргийн сургалтад хамрагдах цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, тэдэнд олгох цалин хөлсний зардлыг тооцож тухайн оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зардлыг хянан батлан хамгаалах үйл ажиллагааны төсвийн төсөлд тусгуулан, батлагдсан төсвийг холбогдох байгууллагад хуваарилна.

3.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараа жилийн цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад хамрагдах цэргийн

бэлтгэл үүрэгтний тоо тэдэнд олгох цалин хөлсний зардлыг тооцож аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн орон нутгийн төсөвт тусгуулна.

Дөрөв. Цэргийн дайчилгаатай сургуульд оролцсон цэргийн бэлтгэл үүрэгтэнд олгох цалин хөлс

4.1. Цэргийн дайчилгаатай сургуульд татан оролцуулсан бэлтгэл офицер, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнд түүнийг оногдуулан бүртгэсэн албан тушаалын зэрэглэлийн үндсэн (төрийн тусгай албан хаагчийн цалингийн сүлжээний нэгдүгээр шатлал) болон цэргийн цолны цалинг оролцсон хоногоор тооцон цэргийн дайчилгаатай сургууль зохион байгуулсан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги олгоно.

4.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб дараа жилийн дайчилгаатай сургуульд татан оролцуулах бэлтгэл офицер, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний тоо, тэдэнд олгох цалин хөлсийг тооцож, тухайн оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Дараа жилийн дайчилгаатай сургуульд татан оролцуулах бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний тоог батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тухайн сургууль зохион байгуулахаас нэг жилийн өмнө тогтооно.

Тав. Бусад зүйл

5.1. Сургалтад оролцсон иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтэн цалин хөлстэй холбогдсон асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хууль хяналтын байгууллагад хандаж болно.

5.2. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 267

Улаанбаатар
хот

Горим батлах тухай

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлтийн горим”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хэв загвар, дээжийн хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой захиргааны актыг энэ тогтоолын 1 дэх заалтад заасан горимтой нийцүүлэх арга хэмжээ авч, шинэчлэн баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2019 оны 267 дугаар
тогтоолын хавсралт

ШИНЖИЛГЭЭНД ЗОРИУЛАН АВСАН ХЭВ ЗАГВАР, ДЭЭЖИЙН ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГОРИМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зөрчил шалган шийдвэрлэх явцад шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас авсан хэв загвар, дээжийг хадгалах, тээвэрлэхэд энэхүү горимыг баримтална.

1.2. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага (цаашид “эрх бүхий байгууллага” гэх) нь хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийг хадгалах, тээвэрлэхтэй холбоотой нарийвчилсан журмыг батлан мөрдөж болно.



Хоёр. Хэв загвар, дээжийг хадгалах

2.1. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан (цаашид “эрх бүхий албан тушаалтан” гэх) зөрчил шалган шийдвэрлэх явцад шинжилгээнд зориулан хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас авсан хэв загвар, дээжийн (цаашид “хэв загвар, дээж” гэх) хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

2.2. Хэв загвар, дээжийг хадгалах байр, өрөө нь биоаюулгүй байдал, биохамгааллын шаардлагыг хангасан орчинтой байх бөгөөд тусгай бэхэлгээ бүхий хамгаалалттай хаалга, цонхтой, ус, чийг, шороо, тоос нэвтрэхгүй, агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай, зориулалтын тоног төхөөрөмжтэй, халаалт, хөргөлтийн системтэй, байнгын дохиолол, камерын хяналт, харуул хамгаалалттай байна. Уг байр, өрөөнд галын аюулгүй байдлыг хангаж, тогтоосон стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллана.

2.3. Хэв загвар, дээжийн хаягжуулалт (дагалдах хуудас)-д байгууллагын нэр, огноо, зөрчлийн хэргийн дугаар, холбогдогчийн нэр, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаалыг тодорхой тусгаж, гарын үсэг, баталгааны тэмдэг хэрэглэж, зөрчлийн хэрэг нээсэн хуулийн заалт, хэзээ, хаанаас бэхжүүлэн хураан авсан зэргийг тодорхой бичсэн байна.

2.4. Хэв загвар, дээжийг хадгалах сав, баглаа боодол нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Цаасан уут”, “Сав баглаа боодол”, “Нийлэг хальсан уут”-ны стандартыг хангасан байна.

2.5. Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хэв загвар, дээжийг шинжилгээ хийхээр томилогдсон шинжээч, мэргэжилтний саналыг үндэслэн эрх бүхий албан тушаалтан байгууллагын даргын, эсхүл нэгжийн даргын зөвшөөрлөөр өөр байгууллагад хадгалуулж болно. Уг хэв загвар, дээжийг хадгалж байгаа байгууллага тэдгээрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, нууцлалыг хангаж ажиллана.

2.6. Түргэн муудах, эмзэг бараа бүтээгдэхүүн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, биологийн гаралтай дээж, тэсэрч дэлбэрэх, ууршиж дэгдэх бодис, цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүр, хүний амь нас, эрүүл мэнд, орчин тойронд аюул учруулж болзошгүй галт хэрэгсэл, амархан дөл авалцдаг болон шатамхай шингэн зэргийг дараахь горимын дагуу хадгална:



2.6.1. түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүний болон гэмтэж, устаж, ялзарч болзошгүй хэв загвар, дээжийг бэхжүүлсний дараа хатаах, үнэрийг нь арилгах арга хэмжээг авч зориулалтын сав баглаа боодолд;

2.6.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис байж болзошгүй дээжийг хадгалахдаа шинж тэмдгийг нь арилахгүй байхаар тооцож жин хэмжээг нарийвчлан бичиж дохиоллын системээр тоноглогдсон байранд буюу цоожтой төмөр шүүгээнд;

2.6.3. биологийн гаралтай хэв загвар, дээж болох хатаасан цусыг тасалгааны температурт, цус цусан бүтээгдэхүүн, үрийн шингэн, шүлс, шээс, өтгөн, ходоодны агууламж /амьтны/, яс /амьтны/ зориулалтын хөргөгчид, үс хумс, эд, эс, зэрэг бусад зүйлийг зориулалтын цаасан хайрцагт, эсхүл шилэн саванд;

2.6.4. түргэн гэмтэх, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах бараа бүтээгдэхүүн, сорьц, үржүүлгийн бүтээгдэхүүний онцлогт тохирсон хэмийг хангаж зориулалтын сав, төхөөрөмж, хөргөгч, хөлдөөгчинд;

2.6.5. галт зэвсгийг хадгалахдаа замаг, хүхээ болон галт зэвсгийг хамтад нь нийлэг уутанд хийн битүүмжилж, зориулалтын шүүгээ, саванд;

2.6.6. цацрагийн үүсгүүрийн 1-5 дугаар ангилалд хамаарах цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг мэргэжлийн байгууллагад хадгалуулах, хяналтаас чөлөөлөгдөх түвшний цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг тусгай саванд хийж, бусад хэв загвар, дээжээс тусад нь байрлуулах;

2.6.7. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис, түүний хаягдлаас авсан хэв загвар, дээжийг мэргэжлийн байгууллагад;

2.6.8. амархан дөл авалцдаг болон шатамхай шингэний дээжийг шатдаггүй материалаар хийсэн, галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хайрцаг, шүүгээнд;

2.6.9. цахим төхөөрөмж, тоон ул мөрийг хадгалахад зориулалтын сүлжээ унагагч, радио долгионоос хамгаалсан уут, саванд;

2.6.10. зам тээврийн осол зөрчилтэй холбоотой тээврийн хэрэгслийг эвдрэл гэмтлийн анхны байдал, хэв загвар, дээжийн шинж байдлыг алдагдуулахгүйгээр гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг гэх мэт)-өөс хамгаалж бүрэн хучиж.

Гурав. Хэв загвар, дээжийг тээвэрлэх

3.1. Эрх бүхий албан тушаалтан нь хэв загвар, дээжийг шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, акт, тэмдэглэл бусад холбогдох мэдээллийн хамт шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

3.2. Хэв загвар, дээжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг гэх мэт)-өөс хамгаалагдсан, холбогдох стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

3.3. Түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн, хадгалалтын онцгой нөхцөл шаардагдах биологийн дээж, сорьц, үржүүлгийн бүтээгдэхүүний дээжийг хөргөх, хөлдөөх болон халуун, хүйтний хэм, чийгийн тохируулга бүхий тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон зориулалтын тээврийн хэрэгслээр зөөвөрлөнө. Зориулалтын тээврийн хэрэгсэлгүй тохиолдолд термометр бүхий мөстэй сав, эсхүл зөөврийн зориулалтын сав, төхөөрөмж, хөргөгчийг ашиглан шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүргэнэ.

3.4. Эрх бүхий албан тушаалтан нь хэв загвар, дээжийн бүрэн бүтэн байдал, нууцлалыг бүрэн ханган битүүмжилж, шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад өөрийн биеэр хүргэнэ. Хэрэв өөрийн биеэр хүргэх боломжгүй бол эрх бүхий албан тушаалтнаар, эсхүл тусгай шуудангаар хүргүүлнэ.

3.5. Хэв загвар, дээжийг тээвэрлэх боломжгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь шинжээчийг хэв загвар, дээж хадгалагдаж байгаа газарт чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүргийг хүлээнэ.

3.6. Халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчинд нөлөөлсөн байж болох хэв загвар, дээж, химийн хорт болон аюултай бодис, химийн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний дээжийг хадгалах, тээвэрлэхдээ хагарч гэмтэхээр бол “Анхаар хагарна”, “Асгарч болзошгүй”, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бол “Тэсэрч болзошгүй”, халдварын сэжиг бүхий бол “Халдвартай”, “Биоаюултай”, химийн хорт болон аюултай бодис бол “Аюултай”, “Хортой” гэсэн таних тэмдгийг сав, баглаа боодол дээр ил, тод харагдахаар хэсэгт бат бөх байрлуулж, шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

3.7. Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий хэв загвар, дээжийг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах бөгөөд ачааны тэмдэгт заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг сахин биелүүлнэ.



Дээжийг тээвэрлэх ажилтанд аюулгүй ажиллагааны талаар зааварчилгааг холбогдох мэргэжилтэн өгсний дараа тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ.

3.8. Энэ журмын 3.7-д заасан хэв загвар, дээжийг тээвэрлэх явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, арьс болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хэрэгслээр тээврийн хэрэгслийг хангасан байна.

3.9. Химийн хорт болон аюултай бодис бүхий хэв загвар, дээжийг тээвэрлэх үед холбогдох мэргэжилтнийг байлцуулна.

3.10. Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн сав, шилэн савны гадуур зориулалтын материалаар хийсэн давхар хамгаалалтын савтайгаар тээвэрлэнэ.

3.11. Тэсрэх, хөлдөөх эрсдэлтэй шингэрүүлсэн хийн шингэнд хадгалсан биологийн дээж, генетик материалыг үйлдвэрлэгчээс савласан давхар ханатай зориулалтын саванд тээвэрлэнэ.

3.12. Соёлын биет өв, аюултай хог хаягдал, цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг шинжилгээ хийх зорилгоор тээвэрлэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 51.2, Хог хаягдлын тухай хуулийн 7.1.2, 7.1.3, Цөмийн энергийн тухай хуулийн 11.1.4-т заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан, гаргасан дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

3.13. Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл дээжийг тээвэрлэхдээ Автотээврийн тухай хуулийн 9.2, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.1, 14.7-д заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

3.14. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх, бодис солилцооны өвчин, хордлогын сэжигтэйгээр өвчлөх, үхэж хорогдох үед түүний шалтгааныг тогтоох, оношлох зорилгоор амьд байгаа малаас болон үхсэний дараахь эмгэг материалаас авсан дээжийг тээвэрлэхдээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу холбогдох байгууллагаас баталсан журмыг дагаж мөрдөнө.

3.15. Шинжилгээ хийх зорилгоор үр, хөрс, бордооноос дээж авах, тээвэрлэхдээ стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Буурцагт ургамлын бактерийн бордоо”, “Ризобактерийн бордоо”, “Сортын болон үрийн чанар” стандартыг тус тус дагаж мөрдөнө.

3.16. Түргэн муудах, эмзэг бараа бүтээгдэхүүнээс авсан хэв загвар, дээжийг хадгалах, тээвэрлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁵.3-т заасныг үндэслэн холбогдох байгууллагаас баталсан журмыг дагаж мөрдөнө.

3.17. Зам тээврийн осол, зөрчилтэй холбоотой тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтлийн анхны байдал, хэв загвар, дээжийн шинж байдлыг алдагдуулахгүйгээр гадна орчны нөлөөлөл (цас, бороо, нар, салхи, шороо, тоос, чийг гэх мэт)-өөс хамгаалж бүрэн хучиж тээвэрлэнэ.

3.18. Хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс хэв загвар, дээжийн шинж чанар алдагдсан тохиолдолд шинжилгээ хийх эрх бүхий байгууллага хүлээн авахаас татгалзах эрхтэй бөгөөд нэн даруй шинжилгээний дээж илгээсэн эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

3.19. Шаардлагатай тохиолдолд хэв загвар, дээжийг тусгай хамгаалалттай тээвэрлэж болно.

Дөрөв.Бусад

4.1. Хэв загвар, дээжийг хадгалах, тээвэрлэх зардлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.2. Хэв загвар, дээжийг лабораторийн шинжилгээнд зориулан авах, шинжилгээ хийх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх, шинжилгээ хийх, устгах, шинжилгээний үр дүнг авахтай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу зохицуулна.

4.3. Хэв загвар дээжийг хадгалах, тээвэрлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулах, түүнийг хувийн сонирхлоор ашиглахыг хориглоно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 271

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл, гэрчилгээний загвар, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл, гэрчилгээний загвар”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2019 оны 271 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ, ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Нэг. Монгол Улсын Засгийн газрын
Хүндэт өргөмжлөл

1.1. Монгол Улсын Засгийн газрын “Хүндэт өргөмжлөл” нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбыг хүндэтгэлийн баганат суурин дээр байрлуулсан зохиомж байна.

1.2. Соёмбо нь алтан шармал өнгөтэй байх бөгөөд баганат суурийг хар ногоон өнгийн хаш үнэт чулуугаар хийсэн байна.

Соёмбын талууд нь 54 мм, өндөр нь 170 мм байна.

Баганат суурин талууд нь 82 мм, өндөр нь 120 мм байна.

Багана нь 20 мм зузаан, 118 мм өргөн давхар суурьтай ба налуу тал дээр нь 60x15 мм алтан шармал ялтас дээр “ХүндэтТанд” “Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл олгов. Он, сар, өдөр” гэсэн бичээс, шагнагдсан хүний овгийн эхний үсэг, нэрийг бичих зай байна.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын Хүндэт
өргөмжлөлийн гэрчилгээ

2.1. Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлийн гэрчилгээ нь 40x28 см-ийн хэмжээтэй дэлгэмэл хуудсан дээр босоо байрлалтай байх бөгөөд гэрчилгээг жаазанд байрлуулсан байна.

2.2 Гэрчилгээний дэлгэмэл хуудсыг тойруулан мөнгөлөг өнгийн түмэн насан хээгээр хүрээлэх бөгөөд хүрээний дотор тал нь бүдэг мөнгөлөг өнгийн түмэн насан хээн дэвсгэртэй байна.

2.3. Гэрчилгээний дээд хэсэгт Төрийн сүлд, түүний дор “Мөнх тэнгэрийн хүчин дор Монголын төрд зүтгэмү” гэсэн Эзэн Богд Чингис хааны алтан гэрэгэний бичээсийг шармал өнгөөр бичнэ.

Түүний доод хэсэгт “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛИЙН ГЭРЧИЛГЭЭ” гэж шармал өнгөөр бичиж доод талд нь гэрчилгээний дугаарыг бичнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын эцгийн болон өөрийнх нь нэрийн эхний үсгийг дугаарын индекс болгон хэрэглэнэ.

Түүний доор нь шагнагдаж байгаа хүний эцгийн болон өөрийн нэр, юуны учир шагнах болсныг бичих зай байх бөгөөд дараа нь “Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнаж гэрчилгээ олгов.” гэсэн үгийг бичнэ.

Түүний доод хэсэгт нь Монгол Улсын Ерөнхий сайд гарын үсэг зурахаар албан тушаалын нэр, гарын үсгийн тайллыг бичиж хэвлэсэн байна.

Гэрчилгээний доод хэсэгт Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан он, сар, өдөр болон Улаанбаатар хот гэж бичнэ.



Засгийн газрын 2019 оны 271 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл нь Монгол Улсын Засгийн газрын дээд шагнал мөн.

1.2. Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл (цаашид “Хүндэт өргөмжлөл” гэх)-өөр Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг ханган, төрийн алба, хууль ёсыг бэхжүүлэх, нийгэм, эдийн засаг, соёл, урлаг, шинжлэх ухаан-техникийг хөгжүүлэхэд гарамгай гавьяа байгуулж, үнэтэй хувь нэмэр оруулсан Монгол Улсын иргэн, төрийн албан хаагчийг шагнана.

1.3. Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, улс түмний эв нэгдэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнийг Хүндэт өргөмжлөлөөр шагнаж болно.

1.4. Хүндэт өргөмжлөлөөр Монгол Улсын болон гадаадын иргэнийг жилд нэг удаа буюу Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт их баяр “Үндэсний их баяр наадам”-ыг тохиолдуулан шагнана.

1.5. Хүндэт өргөмжлөлөөр шагнах асуудлыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.6. Хүндэт өргөмжлөлөөр шагнахад Хүндэт өргөмжлөлийн гэрчилгээ олгоно.

1.7. Хүндэт өргөмжлөлөөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нам, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, цэргийн анги нэгтгэлийг шагнахгүй.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлд
нэр дэвшүүлэх, тодорхойлох

2.1. Энэ журмын 1.2, 1.3-т заасан шаардлагыг хангасан иргэнийг Хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар Монгол Улсын Засгийн газрын гишүүн нэр дэвшүүлэн тодорхойлно.

2.2. Хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар нэр дэвшүүлсэн иргэнийг тодорхойлохдоо энэ журмын хавсралтаар баталсан тодорхойлолт, шагнуулах нэр дэвшүүлсэн Засгийн газрын гишүүний гарын үсэгтэй албан бичиг, зөвлөлийн хурлын шийдвэр, онцгой гавьяа байгуулсан, амжилт

гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, холбогдох шийдвэрийн хуулбар зэрэг материалыг бүрдүүлнэ.

2.3. Хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар нэр дэвшсэн иргэний тодорхойлолт нь үнэн зөв, ажлын үр дүн, гаргасан гавьяа зүтгэл, амжилт, оруулсан хувь нэмрийг товч тодорхой бичсэн байх бөгөөд холбогдох судалгаа, үзүүлэлтийг тусгасан байна.

2.4. Хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан Монгол Улсын иргэнд 2 000 000 (хоёр сая) төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгоно.

2.5. Хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.

2.6. Хүндэт өргөмжлөлөөр иргэдийг шагнуулах материалыг хянан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, бусад үйлчилгээ, дэмжлэг үзүүлж, зохицуулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эрхлэн гүйцэтгэнэ.

Загвар

Зураг

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНДЭТ
ӨРГӨМЖЛӨЛӨӨР ШАГНУУЛАХ ХҮНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ**

1. Овог нэр -----
2. Төрсөн он, сар, өдөр -----
3. Регистрийн дугаар -----
4. Хүйс -----
5. Боловсрол, мэргэжил -----
6. Төрсөн аймаг, хот -----
сум, дүүрэг -----
7. Ажил эрхлэлтийн байдал -----

8. Ажилласан хугацаа.

Нийт: ... жил. Үүнээс: тухайн салбарт жил, тухайн хамт олны дотор ... жил.

9. Төр, засгийн шагналаар шагнагдсан байдал:

10. Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнуулах үндэслэл:

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 13.40 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Баярмаа болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 70 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Ашигт малтмалын тухай хуульд 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.”, 47.3 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:” гээд 47.3.1 дэх заалтад “дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү;”, 47.3.2 дахь заалтад “Энэ хуулийн 47.3.1-т зааснаас бусад төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувь, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаасан алтанд ногдох энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.”, 47.4 дэх хэсэгт “Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.”, 47.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:” гээд 47.5.11 дэх заалтад “Боловсруулаагүй нүүрсний тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-25 хүртэл бол 0 хувь, 25-50 хүртэл бол 1 хувь, 50-75 хүртэл бол 2 хувь, 75-100 хүртэл бол 3 хувь, 100-125 хүртэл бол 4 хувь, 125 ба түүнээс дээш бол 5 хувь,”, 47.5.12 дахь заалтад “Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн)-ийн тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-100 хүртэл бол 0 хувь, 100-130 хүртэл бол 1 хувиар, 130-160 хүртэл бол 1.5 хувь, 160-190 хүртэл бол 2.0 хувиар, 190-210 хүртэл бол 2.5 хувиар, 210 ба түүнээс дээш бол 3 хувь,”, 47.5.13 дахь заалтад “Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)-ний тонн тутмын зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ 0-160 хүртэл бол 0 хувь, 160-190 хүртэл бол 0.5 хувь, 190-210 хүртэл бол 1 хувь, 210-240 хүртэл бол 1.5 хувь, 240-270 хүртэл бол 2 хувь, 270 ба түүнээс дээш бол 2.5 хувь” гэж тус тус өөрчлөн найруулсан байна.

Ашигт малтмалын тухай хуульд орсон дээрх өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эдийн засагт дарамт учруулсан, давхар татвар ногдуулсан, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хаасан, нийгмийн эдийн засгийн хөгжилд саад учруулсан зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох бодит нөхцөлийг үүсгээд байна. Мөн маргаж буй зүйл нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөд зогсохгүй Татварын ерөнхий хуультай зөрчилдөж байх тул хуулийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэх үүднээс Үндсэн хуульд нийцэж



буй эсэхэд дүгнэлт гаргуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн төөрөгдөлд орох, давхар татвар төлөх эрсдэлээс сэргийлэх зүй ёсны хэрэгцээ шаардлага үүсч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж зааснаас үзвэл төр нь нийгмийн хөгжлийг хангах, аж ахуй нэгж байгууллагыг үйл ажиллагаа явуулахад нь эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх бодлого баримталж, эх орондоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээн байгуулалтыг дэмжиж өгөх ёстой гэсэн утга санааг илэрхийлсэн. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд орсон маргаж буй нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн дээрх заалтыг бүхэлд зөрчиж иргэд, аж ахуй нэгжийг давхар татварын дарамтад оруулж, нэг бүтээгдэхүүнд хэд хэдэн татвар ногдуулж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хөгжих боломжийг хааж эдийн засгийн алдагдалд оруулах бодит нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн өмнөх зохицуулалтаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд нь олборлосон бүтээгдэхүүндээ ашигт малтмал ашигласны төлбөр төлдөг байсан бол хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээдүүд бүгд тухайн бүтээгдэхүүний хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар тусгасан нь хуулийн алдааг бий болгосон.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага нь Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалтад заасан 2 төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болоод зогсохгүй, худалдахаар ачуулсан гэсэн үндэслэлээр дахин нэмж татвар төлөхөөр болж, нэг бүтээгдэхүүнээс үндсэндээ дөрвөн татварыг авч байна.

Байгалийн баялгийг олборлосон аж ахуй нэгжээс ашигт малтмал ашигласны төлбөр аваад түүнийг нь боловсруулсан, ашигласан аж ахуй нэгжээс мөн ашигт малтмал ашигласны төлбөр авч, худалдахаар

ачуулсан этгээд дахин нэмж ашигт малтмал ашигласны төлбөр төлөхөөр болж байгаа нь нэг бүтээгдэхүүнээс 3 хэлбэрээр төлбөр авч, мөн дээрээс нь нэмэгдсэн өртгийн албан татвар гээд нийт 4 төрлийн татварыг авч байна. Үүнээс үзэхэд, ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан аж ахуйн нэгжүүд нь нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөөд зогсохгүй ашигласан, худалдахаар ачуулсан гэсэн 3 төрлийн төлбөрийг төлөх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хэт шударга бус байна.

Тэгэхээр Монгол Улсад байгалийн баялгийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн бий болгох аж ахуй нэгж байхгүй болж, уул уурхайн салбар хөгжихгүй байгалийн баялаг эх орондоо үлдэхгүй, эдийн засгийн ямар ч үр өгөөжгүйгээр түүхийгээр хямд өртгөөр экспортод гарсан хэвээр байх дүр зураг харагдаж байна. Монгол Улс нь байгалийн баялаг ихтэй, эдийн засаг нь уул уурхайн салбартай салшгүй холбоотой учир дээрх зөрчлийг арилгахгүйгээр уул уурхайн салбарыг хөгжүүлэх, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ямар ч боломжгүй гэж үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Энэ өөрчлөлт нь алтны ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой юм. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолоор нүүрсэнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зөвхөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авахаар зохицуулсан байгаа.

Мэдээлэл гаргагч мэдээлэлдээ “Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, 7.3.6 дахь заалтад заасан 2 төрлийн татварыг давхар төлөх бодит нөхцөл байдал бий болсон” тухай дурджээ. Давхар татварын тухай асуудал нь нэг этгээдэд нэг татварыг дахин ногдуулахгүй тухай ойлголт бөгөөд бодит байдал дээр олон улс хооронд үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, хувь хүнд тулгардаг асуудал юм.

Тухайлбал, аль нэг улсад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогодоо татвар төлсөн этгээд өөрийн харьяалал бүхий улс оронд дахин тус



татварыг төлөх асуудал үүсдэг. Иймээс тухайн этгээдийн эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангах, өөрийн улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зэрэг олон шалтгааны улмаас тодорхой улс орнууд хоорондоо давхар татварын асуудлыг зохицуулах тухай олон улсын гэрээ байгуулдаг.

Харин орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг нь давхар татварын асуудал биш бөгөөд татварын бүтцэд багтдаг төрөл бүрийн төлбөрүүдийн нэг хэсэг юм. Татварыг дотор нь ингэж төрөлжүүлэн салгахын гол ач холбогдол нь төрөөс эдийн засгийн аливаа харилцааг зохицуулах, хянах зорилгоор татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх явдал юм. Жишээлбэл, Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж заасан байдаг. Эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх асуудлыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн нийгмийн үйлчилгээнд зарцуулах байдлаар хэрэгжүүлдэг. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар бол аливаа бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглээнд татвар оноох буюу шууд бус татварын үр ашгийг сайжруулах зорилготой бөгөөд татварын бодлогын хэрэгжилтийг хянах зорилготой төрийн зохицуулалтын нэг арга хэрэгсэл юм.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээ бол тухайн ашигт малтмалд оноож байгаа давхар татвар биш бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэх буюу бууруулах тухай асуудал юм.” гэжээ.

Гурав. Мэдээлэл гаргагч С.Баярмаа Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллийнхээ нэмэлт тайлбартаа:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад ашигт малтмалын зэрэгцээ Монголбанканд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, татварын суурийг өргөжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан байдаг. Гэтэл татварын суурийг өргөжүүлэх,

тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй хувь хүн, бичил уурхай, баяжуулах үйлдвэр эрхлэгчдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой хуулийн нэмэлт, өөрчлөлт нь нэг бүтээгдэхүүнд өссөн дүнгээр 3 удаагийн төлбөр тооцох бодит нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь Үндсэн хуульд төр нь аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийг хангах эдийн засгийн бодлогыг баримтална гэж заасныг зөрчиж, аж ахуйн үйл ажиллагаанд татварын бодлогоор дарамт учруулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хаасан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Мөн хууль тогтоогчийн зүгээс Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалдаа “энэ хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь төр, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэл сонирхолд бүрэн нийцсэн” гэж худал мэдээлэл оруулж ямар нэг иргэн, аж ахуйн нэгжээс санал аваагүй, хүсэл сонирхлыг нь тусгаагүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй асуудлыг оруулсан. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилго нь зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгах зорилготой гэж тодорхойлж алтны асуудлыг байнгын хороодын хуралдаан, нэгдсэн хуралдаанаараа ярьсан байдаг хэдий ч эцсийн нэмэлт, өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь 3 этгээд байхаар зохицуулж Үндсэн хуулийг зөрчиж шийдвэрлэсэн байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалтын өмнө хэрэгжиж байсан агуулгаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө төлсөн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээс ашигт малтмал худалдан авсан этгээд нь энэ төлбөрийг дахин төлдөггүй байсан бөгөөд шинэ хуулиар ашигт малтмалын нөөц биш бүтээгдэхүүн болсон хэдий ч нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулан Үндсэн хуулийг зөрчиж байна. Хэрэв тухайн бүтээгдэхүүнийг байгалиас нь олборлосон хэвээр буюу түүхий хэвээр нь цааш дамжуулан худалдаж ашиг олж байгаа бол энэхүү хуулийн нэмэлт зохицуулалт нь шударга байх хэдий ч тухайн бүтээгдэхүүнийг боловсруулан нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа явдал нь 2 өөр ойлголт бөгөөд хууль санаачлагч нар үүнийг нарийн ялгаж үзэлгүй эдийн засагт нэмэр болох, татварын суурийг өргөжүүлэх гэсэн санаагаар үйлдвэрлэгчдийг татварын дарамтад оруулахаар хуулийн зохицуулалт хийсэн байна. Мөн үйлдвэрлэгч нь худалдан авагч болохоос биш тусгай зөвшөөрөлтэй газрын байгалийн баялгийг цааш нь дамжуулан худалддаг газар биш бөгөөд дээр



дурдсанчлан 2 өөр ойлголт юм. Үйлдвэрлэгчид нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашигт малтмалын нөөцийг газрын хэвлийгээс олборлодоггүй учир ашигт малтмалын нөөц ашигласан гэж үзэх боломжгүй юм.

Энэхүү хууль нь цаашид Монгол Улсад байгалийн баялгийг эх орондоо нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болгож олон улсын зах зээлд гаргах үйлдвэрлэлийг хөгжүүлэхгүй, үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дарамталсан, үйл ажиллагааг нь боомилсон бөгөөд улмаар энэ салбар цаашид хөгжих боломжгүй болох эрсдэлт нөхцөлийг бүрдүүлж, байгалийн баялгаа өөрсдөөсөө харамлаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хааж, түүхийгээр нь хямд үнээр гадаадын улс оронд гаргаж, их хэмжээний алдагдалд орох маш том эрсдэл, эдийн засгийн хохирол амсах бодит нөхцөл байдал энэхүү хуулийн зохицуулалтын цаана нуугдаж байна. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн ... хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлнэ.” гэснийг зөрчсөн.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэж заасны дагуу 1 хуулийн этгээд ашигласан, худалдахаар ачуулсан гэх үндэслэлээр 2 удаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхөөр зохицуулсан нь хуулийн үзэл баримтлал болон Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хуультай зөрчилдсөн байгаа юм.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцэж, 03 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасан. Энэ хүрээнд Улсын Их Хурал Монгол

Улсын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, улсын хөгжлийн тогтвортой байдлыг хангахад тодорхой нөлөө үзүүлдэг ашигт малтмал буюу эрдэс баялгийн салбарын бодлогыг тодорхойлон холбогдох хууль тогтоомжийг баталсан бөгөөд 2014 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэргийг батлан гаргажээ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 1.2-д “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь ... ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.” гэж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын “Эдийн засгийн тогтвортой хөгжил” гэсэн 2.1-д “... аж үйлдвэр, түүний дотор ... уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч ... хөгжүүлнэ.” гэж заасан байна. Түүнчлэн, дээрх шийдвэрүүдээс гадна Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч болон холбогдох эрх бүхий этгээдээс баталсан 30 орчим шийдвэрт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаарх зохицуулалтыг тусгасан байдаг.

Мөн энэ талаарх зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хуулиудад тусгайлан хуульчилжээ. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт “Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.” гэсэн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж тус хуулийн “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” гэсэн 47 дугаар зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Ингэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын



борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” хэмээн өөрчлөн найруулсан байна. Ийнхүү өөрчлөн найруулахдаа өмнө зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлдөг байсныг ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд бүр төлдөг байхаар хуульчилжээ.

Тодруулбал, ашигт малтмал ашигласны төлбөр гэх нэг төрлийн төлбөрийг тухайн ашигт малтмалыг олборлож, худалдаж байгаа этгээдээс гадна түүнийг худалдан аваад ашигт агуулгыг нэмэгдүүлж, баяжуулан нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэгчээс хүртэл давхардуулан авах боломж бий болгосон байна. Энэ нь дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч иргэдийг дэмжих агуулгагүй, харин улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, түүний тогтвортой байдлыг бий болгох, цаашлаад үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд сөрөг үр дагавар үүсгэх зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтад нийцээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Үүнээс үзэхэд уг заалтаас үүдэлтэй Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчих нөхцөл байдлыг үүсгэжээ.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5.11, 47.5.12 дахь заалтад боловсруулаагүй нүүрсийг хүдэртэй, баяжуулсан нүүрсийг хүдрийн баяжмалтай адилтган ашигт малтмалын ангиллыг буруу тусган нэмэлт төлбөр авахаар зохицуулсан нь хууль зүйн зохицуулалтын зорилго, түүний агуулгатай зөрчилдсөн байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн

хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурал нь хууль тогтоогчийн хувьд Үндсэн хуульд заасан өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулан өөрчлөх боломжтой юм.

4. Мэдээлэл гаргагч С.Баярмаа хуралдааны явцад Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэж мэдээллийн шаардлагаа ихэсгэсэн боловч энэ талаар хангалттай үндэслэл, нотолгоо гаргаагүй байх тул Үндсэн хуулийн дээрх заалт зөрчигдсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.” гэсэн.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

“1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь



хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн "Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө." гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай." гэсэн байна.

Тав. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд 70 дугаар тогтоолыг гаргасан байна. Үүнд:

"1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн "Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө." гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна." гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019

оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцээд дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн:

1. Ашигт малтмал олборлохоос эхлээд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэгч хүртэл үе шатанд татварыг давхардуулан авах боломжийг бий болгосон гэсэн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална.”, 47.7 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хүдэр, баяжмал, бүтээгдэхүүнд давхардуулахгүйгээр ногдуулна.” гэсэн өөрчлөлтийг оруулсан. Эдгээр өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгдсөн аливаа бүтээгдэхүүнд нөөц ашигласны төлбөр дахин ногдуулахгүй тухай зохицуулалт юм.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэж алтны ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлосон алтаа хувь хүн, бичил уурхайн нэр дээр банканд тушааж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс зайлсхийдэг зөрчлийг арилгасны зэрэгцээ татвар давхар ногдуулахгүй байх эрх зүйн орчныг тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.6, 47.7 дахь хэсэгт бүрдүүлж өгсөн.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5.11, 47.5.12 дахь заалтад боловсруулаагүй нүүрсийг хүдэртэй, баяжуулсан нүүрсийг хүдрийн баяжмалтай адилтган ашигт малтмалын ангиллыг



буруу тусган нэмэлт төлбөр авахаар зохицуулсан гэж дүгнэснийг хүлээн авах боломжгүй байна. Төрөөс эдийн засгийн харилцааг зохицуулахдаа орлогын, ашигт малтмалын нөөц ашигласны, нэмэгдсэн өртгийн зэрэг олон төрлийн татварыг ашигладаг. Жишээ нь, Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж заасан байдаг.

Төрөөс энэхүү заалтын хүрээнд эрдэс баялгийнхаа ашиглалтаас ард түмэндээ хүртээх асуудлыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн нийгмийн үйлчилгээнд зарцуулах байдлаар хэрэгжүүлдэг. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар бол аливаа бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглээнд татвар оноох буюу шууд бус татварын үр ашгийг сайжруулах зорилготой бөгөөд татварын бодлогын хэрэгжилтийг хянах зорилготой төрийн зохицуулалтын нэг арга хэрэгсэл юм. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.5 дахь хэсэгт заасан ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн хувь хэмжээ бол тухайн ашигт малтмалд оноож байгаа давхар татвар биш бөгөөд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэх буюу бууруулах тухай асуудал юм.

Дээр дурдсаныг үндэслэн Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.3, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй.” гэсэн байна.

Долоо. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлбартаа:

“... Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.”, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “хуулиар ногдуулсан албан татвар төлөх;” гэж тус тус заасан. Ашигт малтмалын тухай хуульд 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ болон ашигт

малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг өөрчлөөгүй, зөвхөн татварын бааз суурийг нэмэгдүүлэх өөрчлөлт бөгөөд шударгаар татвараа төлж буй этгээдүүдэд нэмэлт татварын ачаалал үүсгээгүй болно.

Ашигт малтмалын тухай хуулийн маргаан бүхий 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн тухайд: Монголд Улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар хурдацтай хөгжиж уул уурхайн бизнесийн олон төрлийн харилцаа бий болсонтой холбоотойгоор ашигт малтмалыг олборлон дотоод, гадаадын зах зээлд борлуулж буй этгээдүүдээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн хураан авч төсөвт төвлөрүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсч уг салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ачаалал харилцан адилгүй болж шударгаар өрсөлдөхөд хүндрэлтэй нөхцөл байдал бий болсон. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн олборлосон ашигт малтмалыг дотоодын зах зээлээс худалдан авч түүхийгээр болон баяжуулан экспортлох, мөн бичил уурхай эрхлэгчдээс ашигт малтмалыг худалдан авч экспортлох зэрэг бизнесийн харилцаанаас үүдэлтэйгээр тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрөлгүй этгээдүүдийн экспортолсон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж байсан 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхай эдэлбэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг татварын алба давхардуулан ногдуулж байсан тохиолдол байхгүй юм.

Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөн найруулсан 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг болон Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын хүрээнд цаашид ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй. Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 3 дахь хэсгийн 3.4-д ашигт



малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй байх зарчим баримтлахаар заасан. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалыг дотоодын зах зээлээс тусгай зөвшөөрөлтэй этгээдээс худалдан авч түүхийгээр болон баяжуулан гадаад зах зээлд борлуулсан тохиолдолд тусгай зөвшөөрөлгүй этгээдийн экспортолсон ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс тухайн ашигт малтмалын бүтээгдэхүүнд тусгай зөвшөөрөлтэй этгээдийн дотоодын зах зээлд борлуулахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулан тайлагнасан дүнг хасаж тооцохоор зохицуулсан.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1 дэх заалт, 47.4 дэх хэсэг болон 47.5 хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалтуудтай холбоотой асуудлаар татвар төлөгчдийн зүгээс санал, гомдол манай байгууллагад гаргаж байгаагүй бөгөөд харин татвар төлөгчийн **ашигт** малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлагнал, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагчийн акттай холбоотойгоор Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж байсан байна. Уг заалтууд нь 2010, 2011 оноос хойш хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд уг заалтуудыг татвар төлөгчид болон татварын албаны зүгээс нэгдсэн ойлголтодтойгоор хэрэгжүүлж байна. ..." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн "Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө." гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... Улсын Их

Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заажээ. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 70 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна.

3. Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Журам батлах тухай” 342 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ыг, 02 дугаар хавсралтаар “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам”-ыг баталсан байх бөгөөд Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Татварын ерөнхий газраас тус маргаанд холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа Засгийн газрын дээрх тогтоолд тусгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй байх зохицуулалтыг тодорхой тусгасан хэмээн дурдсан боловч тус тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлээгүй байх тул хүчин төгөлдөр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйл, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн



47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 70 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

Н.ЧИНБАТ

Ш.ЦОГТОО

Д.СОЛОНГО

Б.БУЯНДЭЛГЭР

Г.ТУУЛХҮҮ

Ш.СОЛОНГО

Ц.НАНЗАДДОРЖ

Г.БАЯСГАЛАН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,25

Индекс: 200003